



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/516

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн
төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, 46.3, 3 Засгийн газрын "Дүрэм шинэчлэн батлах тухай" 2021 оны 212 дугаар тогтоол, Засгийн газрын "Захиалагчийн дүрэм батлах тухай" 2017 оны 170 дугаар тогтоол, Засгийн газрын "Журам батлах тухай" 2021 оны 160 дугаар тогтоол, Сангийн сайдын "Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай" 2021 оны 124 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын "Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай" 2022 оны А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Япон улсын Засгийн газрын Өвсний үндэс-Хүнсний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн зардлаас Рашаант сумын сургуулийн засварын ажлын гүйцэтгэгч сонгох **ХӨАОНӨГ/202305123** дугаартай тендерт 704,480,668 (Долоон зуун дөрвөн сая дөрвөн зуун наян мянга зургаан зуун жаран найман) төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Сайрын Харгана" ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. "Сайрын Харгана" ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, ажлын үе шатны хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий "Захиалагчийн төлөөлөгч"-өөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Батбилгүүн)-ийг томилж, барилга байгууламжийн ажлыг ашиглалтад хүлээн авах хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Батбилгүүн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Ажлын хэсгийн гишүүд: Д.Батчулуун ("Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал)
Ц.Түвшинсайхан ("Сайрын Харгана" ХХК-ийн захирал)
Б.Баттогтох (Рашаант сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал)
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: П.Галсандорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол, шинжлэх ухааны бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн)

3. Рашаант сумын сургуулийн засварын ажил нийлүүлэх гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэлд үе шатны хяналт хийх, ил далд ажлын актыг баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, барилга байгууламжийг ашиглалтад оруулахад шаардлагатай баримт бичгийг бэлтгэж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт

хүргүүлэх, барилгын ажлын үе шатанд хяналт хийж, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тайлагнах, уг тайланг хавтаст хэрэг болгон орон нутгийн өмчийн газрын архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Батбилгүүн), (Д.Батчулуун)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээт ажлын үе шатны хяналтыг хийж, баталгаажуулсан техник хяналтын нэгдсэн дүгнэлт, зохиогчийн дүгнэлт, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон Орон нутгийн өмчийн газрын архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Төмөр)-д тус тус даалгасугай.

4. Барилгын ажлын үе шатны хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг гэрээний дагуу "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-т барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажиллагаатай холбогдон гарах зардлыг ажил хүлээн авах ажлын хэсгийн гишүүдэд тус тус олгохыг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ